



Увс аймгийн
Тариалан сумын
нийгэм эдийн засгийн
байдлын танилцуулга
Сүүлийн 10 жилээр

Сумын нийгэм эдийн засгийн байдлыг
сүүлийн 10 жилээр харуулав

User

Тариалан сумын Засаг даргын Тамгын газар

Гарчиг

- 1 Түүх
- 2 Сумын сүлд дуу
- 3-байгалийн үзэсгэлэнт газар
- 4 Хүн ам
- 5 Эдийн засаг
 - 5.1 Мал аж ахуй
 - 5.2 Уул уурхай
 - 5.3 Газар тариалан
- 6 Дэд бүтэц
 - 6.1 Дулаан хангамж
 - 6.2 Зам тээвэр
 - 6.3 Эрчим хүч
 - 6.4 Усан хангамж

Түүх

Тус сум анх Дөрвөд далай хан аймгийн Зоригт хааны хошууны Алтан тээл сум нэртэйгээр 1925 онд байгуулагдаж, 1934 онд Увс аймгийн Тариалан сум нэртэй болжээ. Энэ нь тус сумынхан, түүний дотор сумын хүн амын зонхилох хэсэг болох хотон ястангууд газар тариалан голлон эрхэлдэг ардын уламжлалт арга туршлага эзэмшсэн, түүнийгээ тухайн нөхцөл байдалд зохицуулан улам баяжуулан ажиллаж амжилтанд хүрдгээс шалтгаалан “**ТАРИАЛАН**” хэмээн нэрлэжээ. Анх Тариалан сум нь 8 багтайгаар байгуулагдаж байв.

1. Намир буюу 1-р баг /одоогийн Бургастай баг/
2. Ёл буюу 2-р баг /одоогийн Тарвагатай баг/
3. Алтан тээл буюу 3-р баг /одоогийн Мянган баг/
4. Бошигт буюу 4-р баг /одоогийн Хөхөө баг/
5. Хархираа буюу 5-р баг /одоогийн Улаангом сумын Хархираа баг/
6. Босго, Сүүж, Зүүн шил буюу 6, 7, 8-р баг /одоогийн Наранбулаг сумын Алдар баг/

1952-1990 он хүртэл нэгдэлжих хөдөлгөөн ялсаны дараахан багийн зохион байгуулалт “Бригад”-ын тогтолцоонд шилжиж өөрчлөгдөж байсан хэдий ч 1991 оноос Засаг захиргааны нэгжийн шинэ зохион байгуулалтанд орж

1. Бургастай
2. Тарвагатай
3. Мянган
4. Толь
5. Хөхөө гэсэн 5 багтай болж 1999 онд Хархираа багийг нэгтгэснээр 6 багтайгаар одоог хүртэл үйл ажиллагаагаа явуулж байна.

Хамгийн өндөрт өвөлжиж, хамгийн нам дор газар намарждаг ард түмэн бол хотон ястангууд бид бүхэн билээ. Учир нь Хархираа ууландаа зусаж, өвөлждөг, Нуурын хөвөөндөө хаваржиж, намарждаг .

Сумын сүлд дуу

Үг. Х.Лхамжав

Ая. Р.Эрдэнэцогт

Авъяаслаг зон олон

Мөнгөн титмээр тэргүүнээ гоёсон

Мөнх цаст Хархираа оргилтой

Од сараар байгалиа шинжсэн

Олныг бишрүүлсэн ажилсаг малчидтай

Бий хуур уламжлалт тариалангаар

Буурал түүхийн шаргал хуудсанд

Алдар нэрээ тодхон мөнхөлсөн

Авъяаслаг зон олон

Хурмаст тэнгэрт тахилаа өргөсөн

Хонхойн хоо ариун шүтээнтэй

Хуурын аялгуунд уяран хөглөгдсөн

Хотлыг баясгасан язгуур бийчидтэй

Дахилт

Буян заяагаар бидэндээ өвлөгдсөн

Бургастай Тарвагатай орд газартай

Ургацын далайд хадууртай сэлсэн

Удам дамжсан шилдэг тариачидтай

Дахилт

Үеийн үедээ магтан дуулагдсан

Үржил шимт Алтан тээлтэй

Өвгөд дээдсээс алдраа дуурсгасан


Өрнүүн хөдөлмөрч ард олонтой

Дахилт

Газарзүй

Тариалан сум нь [,Алтайн нурууны](#) салбар уулс болох Мөнх цаст Хархираан уулсаас [Увс нуур](#) хүртэл үргэлжилсэн 247,9 мянган км хавтгай дөрвөлжин нутаг дэвсгэртэй.

- бэлчээр 95,9%
- ой мод 2,8%
- хадлан, тариалангийн талбай 0,7%
- гол, ус, нуур, цөөрөм 0,6 % -ийг эзэлдэг



Алтай, Хангай, тал хээр хосолсон нутагтай, эх орныхоо алс баруун хязгаарт оршдог.

Увс аймгийн [Наранбулаг](#), [Өлгий](#), [Өмнөговь](#), [Ховд](#), [Улаангом](#) сумуудтай хиллэдэг.

[Улаанбаатар](#) хотоос 1344 км, Улаангом хотоос 31 км алслагдсан, газар нутгийн хувьд ерөнхийдөө өндөрлөг, далайн түвшнээс дээш 1100-1550 м-т хамгийн өндөр цэг нь мөнх цаст Хархираан ноён оргил “Хүйтэн” 4126м-т оршдог.

Эрс тэс уур амьсгалтай. Хархираа, Түргэний болон Цагаан салаа, Харгайт, Гурван хороо, Бургастай, Орлого, Намир зэрэг том жижиг голууд, Их бага Адуун нуур, Яст, Шар, Хар зэрэг нууруудтай.




Буга, янгир, аргаль, ирвэс, шилүүс, дорго, нохой зээх, гахай зэрэг ховор амьтад нутаглаж, агь, ерхөг, арц, таана, хөмүүл, сонгино, тошлой, үхрийн нүд, нохойн хошуу, тэхийн шээг зэрэг эмийн болон бэлчээрийн ургамал ургадаг.

Байгалийн үзэсгэлэнт болон түүхийн дурсгалт газар:

Австрийн аялал жуулчлалын ОУБайгууллагаас манай сумын Хархираа, Намирын эхэн, Залаат орчмын газар нутгийг “Дэлхийн онгон байгалийн аялал жуулчлалын шилдэг 50 газрын нэг” хэмээн дүгнэсэн байдаг

.Халхаатын дэнж, Тээлийн хүн чулуу, хяргасүүр, хадны бичээс, хаад ноёдын буурь, Галданбошигт хааны үед татсан суваг шуудуу, тариа нөөцөлдөг гурван унхараг, морин болон усан тээрмийн буурь зэрэг түүхийн дурсгалт газрууд олон билээ.

Мөн амралт, аялал жуулчлалын чиглэлээр :

-  Тээл парк
-  Баг улиас
-  Хар үзүүрийн байгал эх аялал жуулчлалын гэр базууд үйл ажиллагаагаа явуулж байна.

2014 онд байгалийн үзэсгэлэнт газар болон түүх соёлын дурсгалт газруудаас сумын “**Есөн гайхамшиг**”-ийг тодруулж байв.

1. Дэлхийн бөмбөрцөг /Харгаатын гол/
 2. Хонхой хоо /Их тахилгат уул/
 3. Вансэмбэрүү /Залаатын эхэн/
 4. Ёлын баас /Бор хавцал, хавчгийн аман/
 5. Халим хад /харгаатын гол/
 6. Ленин хад /Мянганы хөндий/
 7. Хүн чулуу / хорхойтын зааг/
 8. Тогоо хад / хархираан дэнж/
 9. Мөсөн гол /Хархираан эхэн цагаан салаа/
-

Хүн ам


Хүн амын 89,3% нь үндэсний цөөнх хотон ястан эзэлдэг. Хотон ястаныг шаавай, бурд, оготор, хольдог, хочхэлд, хаснут, шалбаг гэсэн “Долоон элкэн”-д хуваагддаг

Хүн амын тоо, оноор

№	Үзүүлэлт	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
1	Эрэгтэй	1963	1874	1867	1844	1819	1857	1936	1990	2042
2	Эмэгтэй	1978	1909	1906	1892	1860	1857	1917	1962	1980
	Бүгд	3941	3783	3773	3736	3679	3714	3853	3952	4022




Нийгмийн зарим үзүүлэлт



Эдийн засаг


Эдийн засгийн голлох салбар нь нүүдлийн мал аж ахуй, ардын уламжлалт газар тариалан юм. Сумын нутаг дэвсгэр нь уул, гүвээ толгод бүхий тал хээр буюу мал аж ахуй болон газар тариалан эрхлэхэд тохиромжтой. Мөн ашигт малтмал, байгалийн орд, баялаг ихтэй өсөн эрдэнийн орон билээ.

**Төсвийн гүйцэтгэл 2015 он-2333606,9 мян.төг,
2016 он -2567755,3 мян.төг, 2017 он -
2628089,8 мян.төг**






Мал аж ахуй:



	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Нийт малын тоо	90711	101731	123260	126293	136328	154027	159269
Хээлтэгч мал	39683	43869	52075	53319	59881	59881	66033
Бойжсон төл	28616	33274	43116	47492	50371	53703	56230
Том малын зүй бусын хорогдол	1168	891	460	1200	3415	2053	2062

Малын тоо таван төрлөөр



Малын төрөл	Тэмээ	адуу	Үхэр	Хонь	Ямаа
2014	827	1980	4513	66382	49558
2015	827	2324	4953	68251	49938
2016	811	2461	5013	75228	52815
2017	852	2861	5943	86270	58101
2018	915	3002	6148	89665	59539

Мянгат малчдын судалгаа

№	Өрхийн нэр	Харьяа баг	Мянгат болсон он	Малын тоо					
				Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
2	Т. Сосор	Мянган баг	1999	1021		26	165	720	110
3	Д. Мөнх	Мянган баг	1999	1560	8	23	110	1199	220
4	Б. Тольяа	Бургастай баг	2000	1102	12	10	25	655	400
5	Ц. Тогтох	Мянган баг	2000	1575	7	20	48	1100	400
6	И. Чогдон	Мянган баг	2000	1085	8	4	12	851	210
7	Б. Тангад	тарвагатай баг	2001	1047	10	34	53	650	300
8	Ч. Донио	Бургастай баг	2001	1015	12	21	25	802	155
9	Н. Эрдэнэ	тарвагатай баг	2001	1189	8	16	35	930	200
10	Б. Жамсран	Хөхөө баг	2005	1008		14	33	384	577
11	Ш. Тогтох	тарвагатай баг	2005	1018	10	20	25	834	129
12	Д. Отгонжаргал	Бургастай баг	2006	1018	10	20	25	834	129
13	Н. Тараач	Мянган баг	2006	1002		6	6	680	310
14	Д. Тавдаа	тарвагатай баг	2006	1113	8	16	30	765	294
15	Ж. Батсүх	Хөхөө баг	2007	1010		11	79	679	241
16	Н. Батбуян	Мянган баг	2009	1077	13	42	20	611	391
16	Н. Батбуян	Мянган баг	2009	1077	13	42	20	611	391
17	Ч. Насантогтох	Мянган баг	2013	1014	2	7	15	890	100
18	К. Сумьяа	Бургастай баг	2013	1055	7	6	7	872	163
19	Б.Цэндхүү	Бургастай баг	2014	1015	20	28	25	687	255
20	Ш.Цэднээ	тарвагатай баг	2014	1008	0	5	14	735	254
21	Д.Анхбаяр	Мянган баг	2015	1010	12	5	33	660	300
22	Ж.Мөнгөншагай	Толь	2015	1005	0	2	5	500	498

Уул уурхай

Тус сумын газар нутаг алт, нүүрс, төмрийн хүдэр зэрэг байгалийн баялгаар элбэг бөгөөд одоо алтны нөхөн сэргээлтийн 4, нүүрсний 2 компани тус тус олборлолт хийж үйл ажиллагаагаа явуулж байна.

Хар тарвагатайн орд 23 сая 430 тонн нүүрсний нөөцтэй нь тогтоогдон одоо ашиглагдаж байна. Тариалан сумын төвөөс 90 км зайд оршдог. Социализмын үед ойролцоохь гурван сум, хилийн заставын хэрэгцээг хангах зорилгоор судалгаа хийж илрүүлжээ.

Хар тарвагатайн нүүрсний уурхай 1964 оноос эхлэн ажиллаж байгаа. Увс, Ховд аймгийн нүүрсний хэрэгцээг хангадаг, орон нутгийн чанартай уурхай юм. Хар тарвагатайн ордыг түшиглэн, цахилгаан дулааны станц барих төлөвлөгөө бий. Цаашдаа Увсын Хотгор шанага,


Хар тарвагатайн уурхайгаас Баян-Өлгийн Даянтын боомт руу тээвэрлэлт хийгдэхээр яригдаж байна. Хар Тарвагатайн нүүрсний давхаргын хучаас хурдасны зузаан бага учир ил аргаар ашиглахад уул техникийн нөхцөл нь тохиромжтой. Ордын нөөцийг өсгөх ч боломжтой.

Газар тариалан

Хархираан уулнаас эх авч урссан Хархираа голын эхэнд олон мянган жил үргэлжилсэн мөсөн голын үлдэгдэл эдүгээ ч бий алтай, хангай, говийн олон төрлийн шимт өвс, эмийн ургамал, цэцэг, жимс, жимсгэнэ элбэг ургадаг. Мөн хар мод, улиас, хус, бургас, харгана зэрэг модлог ургамалууд ихээхэн ургадаг.

Манай сум нь үржил шимт хөрс шороотой тул газар тариалан эрхлэх, төрөл бүрийн таримал тарих нэн тохиромжтой.

1980 онд ашиглалтад орсон 2000 га талбай усжуулах хүчин чадалтай, 15 км урттай, газар доогуурх хоолой бүхий бороожуулах төхөөрөмж ашиглан жилд 300-450 га талбайд усалгаа хийж хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлж байна.



Дэд бүтэц

Дулаан хангамж

Сумын төв нь 2016 онд “Дулааны станц”-тай болж төсөвт байгууллагууд нь төвийн дулаанд холбогдсон. Хархираа багийн бага сургууль, цэцэрлэгт, эмнэлэг нь бага оврын уурын зуухаар ажиллаж байна. Гал тогоо бүхий газрууд гар галлагаагаар үйл ажиллагаа явуулж байна.



Зам тээвэр

Аймгийн төвөөс сум хүртэл нийт 31 км шороон замаар явдаг. Хөдөөгийн 4, сумын төвийн 2 баг нь мөн хоорондоо шороон замаар холбогддог. 2015 онд сумын төвд 1,6 км-ын урттай сайжруулсан шороон замыг 39,6 сая төгрөгөөр, замын 2 талын боржурыг 10,0 саяар тус тус хийж гүйцэтгэсэн.

Эрчим хүч

Тариалан сум нь Баруун бүсийн эрчим хүчний систем /ББЭХС/-ээр дамжуулан, ОХУ-ын импортын цахилгаан эрчим хүчээр хангагддаг. Сумын нийт өрхийн 60 гаруй хувь нь төвлөрсөн цахилгаан хангамж, хөдөөгийн өрхүүд нь нарны цахилгаан үүсгүүр хэрэглэж байна. Цахилгааны шугам сүлжээг сайжруулж шинэчлэхэд ОНТөсвөөс 2014 онд 5.0 сая, 2017 онд 4.0 сая, 2018 онд улсын төсвөөс 227.0 сая төгрөг зарцуулав.

Усан хангамж

Тариалан сум нь нийт цэвэр усны эх үүсвэрийн 11 гүний худаг, Үүнээс Хархираа баг 3 гүний худагтай. Сумын төвийн айл өрхүүд өвлийн улиралд худагнаас, зуны улиралд Хархираа голын шимт уснаасаа ундаалдаг.

Хөдөөгийн айл өрхүүд ундны усны 9 энгийн гар худаг болон гол мөрөн, булгийн усаар эх үүсвэрээ хангадаг. Малчдын усны хүрэлцээг сайжруулах зорилгоор Бошигтын бух сэргээхэд 14 км урттай суваг шуудууг 12.0 сая төгрөгөөр засварлаж гүйцэтгэв.